



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2020 оны 04 сарын 10 өдөр

Дугаар А/228

Улаанбаатар хот

Хуваарь батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Засгийн газрын 2015 оны 447 дугаар тогтоолоор батлагдсан “Хүн амын хоол тэжээл” үндэсний хөтөлбөрийн 4.2.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 3.1.7.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Үндэсний хэмжээнд 6-59 сартай хүүхдэд “Өндөр тунт А аминдэм түгээх хуваарь”-г хавсралтаар баталсугай.
2. Хуваарийн дагуу түгээлт хийж, тайланг Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвд ирүүлэхийг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга нарт даалгасугай.
3. Бага насны хүүхдийн дархлааг дэмжих, хоол тэжээлийн дутал, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээлэл, сургалт, сурталчилгааг иргэдийн дунд тасралтгүй зохион байгуулж, мэргэшлийн зөвлөгөө, мэдээллээр хангаж ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв /Д.Нарантуяа/-д даалгасугай.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн газар /Т.Энхзаяа/-т үүрэг болгосугай.

САИД



Д.САРАНГЭРЭЛ

Эрүүл мэндийн сайдын  
2020 оны 04 сарын 10 өдрийн  
... дугаар тушаалын хавсралт

### ӨНДӨР ТУНТ А АМИНДЭМ ТҮГЭЭХ ХУВААРЬ

№	Аймаг, дүүрэг	6-11 сартай хүүхэд		12-59 сартай хүүхэд	
		Хүүхдийн тоо	100000 ОУН, ширхэг	Хүүхдийн тоо	200000 ОУН, ширхэг
<b>Аймгууд</b>					
1	Архангай	1094	1094	9924	9924
2	Баян-Өлгий	1677	1677	10935	10935
3	Баянхонгор	1306	1306	7743	7743
4	Булган	882	882	5288	5288
5	Говь-Алтай	829	829	6122	6122
6	Говьсүмбэр	283	283	1839	1839
7	Дархан-Уул	3136	3136	14656	14656
8	Дорноговь	906	906	5954	5954
9	Дорнод	1252	1252	8311	8311
10	Дундговь	560	560	3950	3950
11	Завхан	1446	1446	7755	7755
12	Орхон	2528	2528	10882	10882
13	Өвөрхангай	2622	2622	10920	10920
14	Өмнөговь	960	960	6694	6694
15	Сүхбаатар	1065	1065	8010	8010
16	Сэлэнгэ	2329	2329	11295	11295
17	Төв	1684	1684	10233	10233
18	Увс	2010	2010	8782	8782
19	Ховд	1197	1197	11100	11100
20	Хөвсгөл	2010	2010	12337	12337
21	Хэнтий	1080	1080	7698	7698
<b>Дэд дүн</b>		<b>30856</b>	<b>30856</b>	<b>180428</b>	<b>180428</b>
<b>Фалкон (500 шир)</b>			<b>31</b>		<b>360</b>
<b>Улаанбаатар хот / Нийслэлийн эрүүл мэндийн газарт</b>					
1	Багануур дүүрэг	670	670	2562	2562
2	Багахангай дүүрэг	116	116	417	417
3	Баянгол дүүрэг	5439	5439	24050	24050
4	Баянзүрх дүүрэг	8011	8011	34821	34821
5	Налайх дүүрэг	851	851	3546	3546
6	Сонгинохайрхан дүүрэг	7639	7639	33227	33227
7	Сүхбаатар дүүрэг	3168	3168	13910	13910
8	Хан-Уул дүүрэг	4458	4458	20241	20241
9	Чингэлтэй дүүрэг	3630	3630	15160	15160
10	Асрамж, халамжийн төв	1000	1000	1000	1000
11	НЭМҮТ-ХСА	1000	1000	500	500
<b>Дэд дүн</b>		<b>35982</b>	<b>35982</b>	<b>149434</b>	<b>149434</b>
<b>Фалкон (500 шир)</b>			<b>36</b>		<b>299</b>
<b>Нийт дүн</b>		<b>67838</b>	<b>66838</b>	<b>329862</b>	<b>329862</b>
<b>Нийт фалкон</b>			<b>67</b>		<b>659</b>

**Тайлбар:** Хэрэв 6-11 сартай хүүхдэд 200 000\* ОУН тунтай А аминдэмийг ЭМС-ын 2013 оны 470 дугаар тушаалын дагуу ½ капсул (3 дусал)-ыг 100 000 ОУН-ээр тооцон уулгана.